



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон
Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй
танилцсантай холбогдуулан авах
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг, 16 дугаар зүйлийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл болгосон шийдвэрийн биелэлтийг үндэслэн бүрэн хэрэгжсэн, шийдвэрт заасан хугацаа дууссан үндэслэлээр хяналтын бүртгэлээс хасах Байнгын хорооны тогтоолын холбогдох заалтыг хавсралтаар баталсугай.

2.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх, хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч, үр дүнг танилцуулахыг Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад даалгасугай.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



П.ГАНЗОРИГ

Монгол Улсын Их Хурлын Хүний хөгжил,
нийгмийн бодлогын байнгын хорооны
2024 оны 06 дугаар тогтоолын хавсралт

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ШИЙДВЭРТ ЗААСАН ХУГАЦАА ДУУССАН ҮНДЭСЛЭЛЭЭР
ХЯНАЛТЫН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**

№	Тогтоолын нэр	заалтын дугаар	Заалтын агуулга	Засгийн газраас ирүүлсэн тайлан	Үндэслэл
1	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.06.09. №24	1.14/	Боловсролын салбарын удирдах ажилтнууд болон багш нарын ажлын хариуцлага, ёс зүйг сайжруулахад онцгойлон анхаарч, хуулийн хүрээнд хариуцлага тооцон ажиллах;	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2022 оны Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 20 -ны өдрийн А/545 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг баталж, хэрэгжүүлж байна. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
2	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05 №25	1.9/	Цэцэрлэгийн туслах багшийг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд бэлтгэх;	Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.7-т "мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын мэргэжлийн чиглэл, индексийг батлах" гэсний дагуу политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургуулиар бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс буюу хөтөлбөрийг Боловсролын олон улсын стандарт, ангилал, тодорхойлолт (ISCED-F- 2013)-д нийцүүлэн боловсруулж Боловсролын сайдын 2024 оны А/49 дүгээр тушаалаар батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс/хөтөлбөрт 011203 индекс бүхий "Багшийн туслах"-ын хөтөлбөрийг Мэргэжлийн боловсролын III-IV түвшинд тодорхойлон 2025 онд Хангай мэргэжлийн боловсролын сургууль, Универсал политехник коллеж зэрэг 2 сургалтын байгууллага уг хөтөлбөрөөр сургалт эрхлэхээр хүсэлтээ ирүүлснийг шийдвэрлэж Боловсролын сайдын 2025 оны А/207, А/231 дүгээр тушаалаар энгийн зөвшөөрлийг олгоод байна. 2025-2026 оны хичээлийн жилд 011203 индекс бүхий "Багшийн туслах" хөтөлбөрөөр 1, 3 жилийн хугацаатайгаар бэлтгэх сургалтын хөтөлбөрийн дагуу дээрх 2 сургалтын байгууллагад статистик мэдээ / https://moe.gov.mn/post/170085/ -ээр нийт 77 суралцагч суралцаж байна. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн

3	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.05.22 №14	1.а.5/	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хуулийн тусгайлсан зохицуулалтаар зохицуулж, дэмжлэгийн төрөл, хэлбэр, үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлээр зохицуулж, аж ахуйн нэгж, байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах болон тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
4	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.06.22 №17	2	Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс хийх ажлын төлөвлөгөө гаргаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /С.Чинзориг/-д даалгасугай.	Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 50 дугаар тэмдэглэлийн дагуу мэргэжлийн боловсрол, сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Боловсрол, шинжлэх ухааны яаманд шилжүүлэх тэмдэглэл гарч 2022 оны 02 дугаар сард Боловсролын яаманд шилжиж ирсэн. Мөн 2023 онд шинэчлэн батлагдсан Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028) зэрэгтэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ бүрэн шинэчлэгдсэн. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
5	Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.10.16 №21	1.6/	Хүүхэд, залуучуудад монгол ахуй, монгол өв соёлыг өвлүүлэх, дархлааг бий болгох үүднээс хүүхдүүдэд музейг үнэ төлбөргүй үзүүлдэг байх, хүүхэд, залуучуудын театр, хүүхэлдэйн театр, киноны хүрээлэн бүхий чөлөөт цагийн төв цогцолборыг байгуулах ажлыг эхлүүлэх, хилийн чанад дахь монгол хүүхдэд хэл, соёлоо өвлүүлэн үлдээх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагатай идэвхтэй хамтран ажиллах;	Хилийн чанад дахь монгол хүүхдэд хэл, соёлоо өвлүүлэн үлдээх чиглэлээр эх хэл, түүх, соёлын жишиг сургалтын хөтөлбөрийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2017 оны А/123 дугаар тушаалаар баталсан Монгол хэл соёлын жишиг хөтөлбөрийн дагуу гадаад дахь хэл соёлын төвүүдэд болон Мэдлэг цахим сургууль нь сурагчдадаа хэлний түвшин, насаар ангилан групп болон ганцаарчилсан хэлбэрээр анхан, дунд, ахисан шатны түвшинд сургалт явуулж байна. "Хилийн чанад дахь монгол хэл, соёлын сургалтын байгууллагын үйл ажиллагааны нөхцөл байдлын судалгаа"-г Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хамтран 2024 онд зохион байгуулсан. Хилийн чанад дахь монгол хэл, соёлын сургалтын байгууллагын үйл ажиллагааны нөхцөл байдлын судалгаанаас харахад Монгол хэл, соёлын сургалтын жишиг хөтөлбөрийг сайжруулах, боловсронгуй болгох, бүх оронд ашиглаж болохуйц, хэлний түвшин бүрээр нэгдсэн сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлагатай байна. Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Соёлын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А/32, А/55, А/56, А/151 дүгээр хамтарсан тушаалаар Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэнд эх хэл, бичиг үсэг, үндэстний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, соёлын үнэт зүйлсийг таниулахад чиглэсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн.	хэрэгжсэн

				Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	
6	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021.05.25 №05	1.1/	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2019 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж, холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцсан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн бага ангийн суралцагчдыг өдрийн хоолны үйлчилгээнд хамруулах хүрээнд: 1/сургуулийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг хүн амын зохистой хооллолтын талаарх зөвлөмжид заасан хэмжээ, инфляцийн түвшинтэй уялдуулан шинэчлэн баталж, 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх;	2026 оны төсвийн төсөлд ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч буй суралцагчдын хоолны зардлыг 3000 төгрөгөөр, үдийн хоолны зардлыг 1000 төгрөгөөр нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг судалгаа хийж, 97,3 тэрбум төгрөг 2026 оны төсөвт нэмж шаардагдах тооцоолол гарч, төсвийн төсөлд тусгасан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 6-9 ангийг үдийн хоол хөтөлбөрт хамруулахад 109.3 тэрбум төгрөг шаардлагатай, мөн дунд ангид орон нутгийн төсвийн санхүүжилтээр сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын хэмжээнд 80.3 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцооллыг салбарын хэмжээнд хийж, Сангийн яаманд хүргүүлсэн ч дэмжигдээгүй байна. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 173.2 тэрбум төгрөгийг 2026 оны төсөвт баталсан байна. Үүнээс хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан хоолны түүхий эд, материалын зардалд 59.5 тэрбум төгрөг, энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад дотуур байранд амьдрах хүүхдийн тоог 1,053 орчмоор нэмэгдэж, нийт 36,870 хүүхэд дотуур байранд амьдарна гэж тооцож байна. Дотуур байранд амьдарч буй хүүхдийн хоолны түүхий, эд материалын зардлыг бага ангид 6,000 төгрөг, дунд, ахлах ангид 6,300 төгрөг, үдийн хоолны зардлыг бага ангид 2500 төгрөг, тусгай хэрэгцээт суралцагчдад 3400 төгрөг байхаар тооцож, 2026 оны төсвийг баталсан байна. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн.	хэрэгжсэн
		1.5/	Энэ тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4 дэх дэд заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөвт нэмж шаардагдаж байгаа зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 онд батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2025 онд Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, суралцах орчныг сайжруулах чиглэлээр нийт 221.7 тэрбум төгрөг батлагдаж, 204.6 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн байна. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Боловсролын сайдын багцад нийт 74.6 тэрбум төгрөгийг дээрх чиглэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэлд санхүүжүүлэхээр тусгасан бөгөөд үүнээс "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/" гэсэн төсөл, арга хэмжээнд 2.3 тэрбум төгрөгийн санхүүжүүлэхээр байна.	шийдвэрт заасан хугацаа дууссан.

				Хасах санал: Шийдвэрт заасан хугацаа дууссан.	
		1.6/	Хууль, тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд: 6/ Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулиудыг үдийн хоол үйлдвэрлэлд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийг 2022 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган батлуулах;	Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай" 56 дугаар тогтоолын хавсралтын 2.3.19-д Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулах, нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг шинэчлэх, мэргэжлийн хүний нөөцөөр хангах ажлыг тусгасан. Үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд 2026 онд 1-5 дугаар ангийн нийт 341,946 сурагчийн үдийн хоолны зардалд 141.1 тэрбум төгрөг төсөвлөсөн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/317 дугаар тушаалаар сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг явуулах зориулалтын байр болон түүнд ашиглах тоног төхөөрөмжийг худалдан авах, засвар үйлчилгээ хийхэд зориулсан "андив, тусламжийг хүлээн авах ажлыг зохион байгуулах журам"-ыг баталсан. Энэхүү журмаар төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагчаас санаачлан сайн дурын үндсэн дээр хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын байр болон түүнд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон тэдгээрийг худалдан авах, засвар үйлчилгээ хийхэд зориулан өгсөн хандив, тусламжийг хүлээн авах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа болно. Тайлангийн хугацаанд Орхон, Өмнөговь аймаг, нийслэлд орон нутгийн төсөв, аж ахуйн нэгжийн санаачилга, санхүүжилт, эцэг эхийн дэмжлэгээр сургуулийн хоолны газрын тоног төхөөрөмж, ус шүүгч төхөөрөмжөөр хангасан байна Хасах санал: Шийдвэрт заасан хугацаа дууссан.	шийдвэрт заасан хугацаа дууссан.
		1.8/	багш, ажилчид, эцэг, эх, асран хамгаалагчийн хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх талаар арга хэмжээний санал боловсруулж, хэрэгжүүлэх;	Койка ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах чадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд ШУТИС-ийг түшиглэн "Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт арга зүйн төв"-ийг байгуулан 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдөр нээлт арга хэмжээг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Энэхүү төв нь ШУТИС-ийн төв байрны 800м2 талбай бүхий 9 анги, танхим, 6 өрөөнөөс бүрдэж, тэдгээрийн засвар үйлчилгээнд 541,4 сая төгрөг зарцуулж, 116 нэр төрлийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг суурилуулан бэлэн болгосон байна. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
7	Засгийн газарт чиглэл өгөх тухай	6/	Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022.03.23-ны 05 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн	хэрэгжсэн

	2021.10.19 №05		эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2 дахин нэмэгдүүлэх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлийн санхүүжилтийн хэлбэрт бүрэн шилжүүлэх;	анхан шатны тусламж, үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж шинэчлэн тогтоосон. Улмаар ЭМДҮЗ-ийн 2023.06.28-ний 06 дугаар тогтоол, 2024.03.29-ний 05 дугаар тогтоол, 2025.01.23-ны 03 дугаар тогтоолуудаар тус тус шинэчлэн тогтоож, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлийн санхүүжилтийн хэлбэрт бүрэн шилжүүлээд байна. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	
		11/	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын чиг үүргийг батлагдсан орон тооны дагуу 2021 оны 12 дугаар сард багтаан шилжүүлэх;	Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор 2022 оны 01 дүгээр сараас мэргэжлийн хяналтын төв орон нутгийн байгууллагын эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч нарыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт шилжүүлсэн. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
		12/	Нийслэл, аймаг, сумын бүх шатлалын эмнэлгүүдэд салбарын холбогдох хууль, тогтоомжууд болон санхүүжилтийн шинэчлэлийн талаар тайлбарлан таниулах сургалтыг тогтмол зохион байгуулах, гүйцэтгэлийн санхүүжилтийг цаг тухайд нь алдагдалгүй авах нөхцөл боломжоор тухай бүр хангаж ажиллах;	2025.03.10-ны өдөр нийслэлийн харьяа 28 эрүүл мэндийн байгууллагын 84 удирдах ажилтанд Эрүүл мэндийн салбарын шинэчлэл, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төлбөрийн арга, төсвийн гүйцэтгэл, тайлагналт, болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолын танилцуулгын талаар сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн 2025.06.06-ны өдөр “Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмнэлгийн санхүүгийн удирдлага” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, салбарын холбогдох хууль тогтоомж болон санхүүжилтийн шинэчлэлийн тайлбарлан таниулах сургалтыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, нийслэл дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтан зэрэг 100 хүнд сургалт зохион байгуулсан. https://www.emg.ub.gov.mn/a/122118 Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
8	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг	1.5/	бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох,	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангахаар жил бүрийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар биеийн тамирын хичээлийн тоног төхөөрөмжийг худалдан авч, сургууль, цэцэрлэгүүдэд олгосон. 2025 онд	хэрэгжсэн

	хангах зарим арга хэмжээний тухай 2021.10.19 №08		тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	499.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмжийг нийлүүлсэн бол 2026 онд 562.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	
		1.7/	Монгол Улсын үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэл, сургуулилт хийх орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор "Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв"-ийг байгуулах ажлыг шуурхай зохион байгуулах;	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Булган аймгийн Хангал сумын нутаг дахь "Спортын бэлтгэл, сургалтын төв" ТӨААТҮГ-ыг "Техник спортын төв" ТӨААТҮГ-тай нэгтгэх, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний ээлжит хуралдаанаар "Буянт-Ухаа спортын ордон" ТӨААТҮГ-ыг Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв ТӨААТҮГ-т нэгтгэн зохион байгуулах Засгийн газрын 243 дугаар тогтоолууд гарч батлагдсан. "Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв" ТӨААТҮГ нь Монгол Улсад биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулж, биеийн тамир спортын талаар төрөөс баримтлах бодлого чиглэлийн хэрэгжүүлэх чиглэлээр ажиллан, спортын амжилтыг ахиулахад ихээхэн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Хуучнаар Техник спортын төв нь буудлагын спортын тамирчдын олимпын бэлтгэлийг хангах, Үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тив дэлхийд өрсөлдөх чадвартай тамирчдыг бэлтгэх цорын ганц зориулалтын спортын нэгдмэл байгууламж юм. Булган аймгийн Хангал сумын нутаг дахь "Спортын бэлтгэл, сургалтын төв" ТӨААТҮГ нь төрөл бүрийн спортын баг тамирчдыг өндөр уулын бүсэд шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт дасгалжуулалтын үйл ажиллагааг явуулах, томоохон тэмцээний дараах тамирчдыг ачааллыг бууруулж, бие бялдрыг нь нөхөн сэргээж сайжруулах зориулалтай улсын хэмжээний байгууллага болон ажиллаж байна. Харин "Буянт-Ухаа спортын ордон" ТӨААТҮГ нь Монгол Улсад буй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын заал, талбай бүхий байгууламж бөгөөд манай оронд болж байгаа олон улс, тив, дэлхийн томоохон тэмцээн, үндэсний хэмжээний тэмцээн, наадмуудын шигшээ тоглолтуудыг хүлээн авч явуулдаг зориулалтын байгууламж юм. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
9	"Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль	1.6/	Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд аудит хийлгэн, аудитын дүгнэлтэд үндэслэн	Боловсролын сайдын 2024 оны "Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай" А/207 дугаар тушаалын дагуу Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн 2023 он, 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийж	хэрэгжсэн

	батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022.01.17. №01		шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх.	ажиллалаа. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх бүх талын арга хэмжээ авч ажиллахын зэрэгцээ төлөвлөгөө гарган, тодорхой албан тушаалтнуудад хариуцуулан анхаарч ажиллахыг зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	
10	Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2022.05.11 №06	1.4/	хүүхдэд үйлчилдэг болон хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг байгууллагыг тамхигүй орчин болгох, дам тамхидалтаас сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Ерөнхий боловсролын сургуулийн орчныг тамхигүй орчин болгох, дам тамхидалтаас сэргийлэх, хамгаалах зорилгоор Боловсролын сайдын "Боловсролын сургалтын байгууллагын орчинд электрон тамхи хэрэглэхийг хориглох тухай" 2024 оны А/140 дүгээр тушаал гарч, сургалтын байгууллагуудад хүргүүлсэн. Тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалах үйл ажиллагааны зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт ирүүлсэн 1,202 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг хүлээн авч, 70 объектын байршил ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор байршилтай, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтыг хангахгүй байх тул буцаасан. ЭМЯ-ын Салбарын хяналтын газрын даргын баталсан 2025 оны 10-00/03 дугаартай "Тамхи, тамхин бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдахад эрүүл ахуйн дүгнэлт гаргах тухай" удирдамжийн хүрээнд: Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.10.3, 7.11.3 дахь заалтын дагуу тамхи, тамхин бүтээгдэхүүний хорт бодисын агууламж, чанар, аюулгүй байдалд дүгнэлт гаргуулах 7 аж ахуйн нэгжийн давхардсан тоогоор 16, үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах 1, тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалах үйл ажиллагааны зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт ирүүлсэн 1,202, нийт 1,219 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн

11	Чиглэл өгөх тухай 2023.03.28 №05	1.1.1/	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;	1.Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлагдсан. https://legalinfo.mn/mn/detail?lawid=17140463602711 2.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Түүнчлэн 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжсэн. https://d.parliament.mn/tusul/1591e85c-f4ef-4fcf-90e7-a0f708b9bb18 3.Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. https://d.parliament.mn/tusul/ee209373-9bd6-43bf-a87b-4b322b307ff2 Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
		1.2.6/	Хүүхдийн эрхийн байцаагчийн чиг үүргийг боловсронгуй болгох, нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх.	УИХ-аас 2024 онд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хамт Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан. Хуульд улсын байцаагчийн мэргэжлийн шаардлага, эрх зүйн хэм хэмжээг тодорхой болгон хуульчилсан. Мөн Засгийн газрын 2024 оны 142 дугаар тогтоолоор Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрэм, 2024 оны 143 дугаар тогтоолоор "ХЭУБ-ын орон тоо"-г тогтоосон. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
12	Чиглэл өгөх тухай 2025.03.26 №03	1.14	Малчнаас 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны 1 хүүхдийг мал аж ахуйн тэжээл, бэлчээр судлалын чиглэлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй сургах журмыг боловсруулан батлуулах;	Засгийн газрын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" 215 дугаар тогтоолоор "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам"-ыг шинэчлэн баталсан бөгөөд журмын 7.2.2-т малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжил эзэмшүүлэх зорилгоор төрийн өмчийн сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгох зохицуулалт тусгасан байна. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	хэрэгжсэн
		1.15	Монгол Улсад дутагдалтай байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажилладаг мэргэжилтэн бэлтгэхийг дэмжих хүрээнд хэл засалч, хөдөлгөөн засалч, протез техникч, хөдөлмөр засалч зэрэг мэргэжлүүдийг тэргүүлэх болон	Байнгын хорооны чиглэлийн дагуу Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам"-ын 7.2.4-т хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн хэл засал, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, сэтгэл зүй, арга зүй (эрүүл мэндийн, спортын) зэрэг мэргэжлийн үндсэн хөтөлбөрөөр суралцагчдад тэтгэлэг олгох, 7.3-т гадаадын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрөөр тэтгэлэгтэйгээр суралцах, 7.4-т дотоодын	хэрэгжсэн

		эрэлттэй мэргэжлийн жагсаалтад оруулах, уг мэргэжлээр суралцаж төгссөн иргэдийг боловсролын байгууллагаас гадна, сургалтын эмнэлэг, сувилал, сэргээн засах төв эмнэлэг зэрэг байгууллагуудад ажиллах тохиолдолд дахин 1 удаа давтан суралцуулахыг дэмжих зохицуулалтыг тусгах.	сургалтын байгууллагад дэд бакалавр болон бакалаврын үндсэн хөтөлбөрөөр хоёр дахь удаагаа суралцах боломжийг тус тус зохицуулсан. Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	
Байнгын хорооны 12 тогтоолын 20 заалт				

—o0o—